



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/59

Мөрөн сум

Хөрөнгө худалдах, актлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.12, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа илүүдэлтэй, засварлаж ашиглахад эдийн засгийн хувьд үр ашиггүй барилга, байгууламжийг хавсралтаар баталж, хөрөнгийг дуудлагаар худалдах, актлах ажлыг зохион байгуулахыг Орон нутгийн өмчийн газарт зөвшөөрсүгэй.

2. Хавсралтаар баталсан хөрөнгийг байгууллагынхаа данс бүртгэлээс хасах, дуудлага худалдааны орлогыг журмын дагуу аймгийн Хөрөнгө борлуулсны орлогын данс болон холбогдох дансанд төвлөрүүлэх, зарцуулахыг Орон нутгийн өмчийн газар, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Дор дурдсан арга хэмжээ авч, биелэлтийг гаргаж, аймгийн Орон нутгийн өмчийн газарт ирүүлэхийг орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал нарт даалгасугай.


а. Үндсэн хөрөнгийг худалдан борлуулах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

б. Хөрөнгийн хөдлөлийг хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэлд тусгах.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Төмөрхуяг)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Г.МӨНГӨНХУЯГ



8712001195

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2023 оны 06 дугаар сарын 08 ны өдрийн 19/ДЗ дугаар захирамжийн хавсралт

а/ Барилга, байгууламж

№	Аймаг, сумын нэр	Байгууллагын нэр	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ /төг/	Байгуулсан үнэ /мян.төг/	Үлдэгдэл үнэ /мян.төг/	Данснаас хасах шалтгаан	Байгууллагын санал /төг/	ОНӨГ-ын үнийн санал /төг/	Аймгийн ИТХ-ын шийдвэр /төг/
1	Тариалан	Хөвсгөл аймгийн Тариалан сумын Эрүүл мэндийн төв	Эхийн амрах байр	2008	м.кв	48	11 381 731,20	2 667 593,25	8 714 137,95	Хөвсгөл аймгийн Тариалан сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 06 сарын 14-ний өдрийн 63 дугаар албан тоот	Газар чөлөөлөх, худалдах 2,000,000	Газар чөлөөлөх, худалдах 2,000,000	Газар чөлөөлөх, худалдах 2,000,000
Дүн							11 381 731,20	2 667 593,25	8 714 137,95				

000